

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/14/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichnkhlorlooga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
4. Аудитын тайлан	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар



ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГА
ДАРГА Б.ЦЭРЭН-ОЧИР ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.23 № 01/279
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудаас ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжсэнээр 3,795.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 393.3 сая төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 63.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч нэр төрлөөр нь авч үзвэл 13.8 сая төгрөгөөр тасарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Цагааннуур сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 82.6 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт

олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	953,808.4	494,804.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	399,121.1	363,133.6
33	АВЛАГА	114,999.0	83,196.8
35	БАРАА МАТЕРИАЛ	439,688.2	48,474.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,245,148.7	531,729.4
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	1,666.7	0.0
37300	Урт хугацаат зээл	1,666.7	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,243,482.0	531,729.4
39200	Биет хөрөнгө	3,994,450.9	469,607.1
39300	Биет бус хөрөнгө	249,031.1	62,122.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,198,957.1	1,026,533.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,261.5	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,261.5	0.0
41300	Өглөг	1,261.5	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,197,695.6	1,026,533.9
51	Засгийн газрын хувь оролцоо	5,197,695.6	1,026,533.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,234,061.4	225,884.8
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,234,061.4	225,884.8
51200	Хуримтлагдсан үр дүн	2,943,282.0	665,159.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,020,352.3	135,489.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,198,957.1	1,026,533.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,403,377.3	902,013.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	81,760.6	242,680.9
110	Орлогын албан татвар	32,482.4	149,259.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	32,482.4	157,297.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-8,038.2
113	Хөрөнгийн албан татвар	650.0	12,488.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	48,628.2	80,932.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	778,014.6	50,572.8
120	Нийтлэг татварын бус орлого	778,014.6	50,572.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,543,602.1	608,760.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,642,415.6	847,815.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,642,415.6	847,815.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,528,460.1	714,475.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,553,217.5	309,944.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	204,167.4	38,579.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,591.5	129,487.8
2104	Хангамж, бараа материалын зардал	120,995.0	71,738.6
2105	Нормативт зардал	222,192.3	83.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,196.7	58,290.2
2107	Томилолт, зочны зардал	5,045.9	2,411.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,710.4	24,120.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	263,343.5	79,820.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,955.5	133,339.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	760,961.8	54,198.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,831.2	4,188,476.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	747,130.5	-4,134,278.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,645,036.6	862,936.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	81,760.6	242,680.9
110	Орлогын албан татвар	32,482.4	149,259.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	32,482.4	157,297.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-8,038.2
113	Хөрөнгийн албан татвар	650.0	12,488.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	48,628.2	80,932.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,078.0	14,713.9
1181	Газрын төлбөр	2,287.2	10,469.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	41,262.9	55,749.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,335.7	11,495.9
120	Нийтлэг татварын бус орлого	41,335.7	11,495.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,521,940.3	608,760.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,316,034.7	890,954.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,316,034.7	890,954.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,202,079.2	613,620.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,552,527.6	309,944.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	206,685.9	38,599.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,694.5	125,006.7
2104	Хангамж, бараа материалын зардал	118,192.1	37,112.8
2105	Нормативт зардал	138,115.9	2,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,389.7	57,873.4
2107	Томилолт, зочны зардал	4,872.5	2,411.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,740.1	26,191.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,860.9	14,480.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,955.5	277,333.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	329,001.9	-28,017.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	118,953.2	7,970.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	118,953.2	7,970.0
2200	Дотоод эх үүсвэрээр	118,953.2	7,970.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-118,953.2	-7,970.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	210,048.7	-35,987.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	189,072.4	399,121.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	399,121.1	363,133.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,450,565.1	4,450,565.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	52,558.4	52,558.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,503,123.6	4,503,123.6
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-52,558.4	-52,558.4
9	Тайлант үеийн үр дүн	747,130.5	747,130.5
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,197,695.6	5,197,695.6
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,197,695.6	5,197,695.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-36,882.8	-36,882.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,160,812.8	5,160,812.8
19	Тайлант үеийн үр дүн	-4,134,278.9	-4,134,278.9
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,026,533.9	1,026,533.9

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	976,920.2	862,187.1	114,733.1	88.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	956,920.2	862,187.1	94,733.1	90.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	672,651.7	611,882.8	60,768.9	91.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349,695.3	309,944.9	39,750.4	88.6
210101	Үндсэн цалин	303,393.8	263,744.4	39,649.4	86.9
210102	Нэмэгдэл	29,801.5	31,035.6	(1,234.1)	104.1
210104	Урамшуулал	16,500.0	15,164.9	1,335.1	91.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,126.4	38,599.7	6,526.7	85.5
210201	Тэтгэврийн даатгал	31,121.6	26,805.9	4,315.7	86.1
210202	Тэтгэмжийн даатгал	3,501.2	3,150.6	350.6	90.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,801.0	2,480.2	320.8	88.5
210204	Ажилгүйдлийн даатгал	700.1	560.3	139.8	80.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,002.5	5,602.7	1,399.8	80.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,609.2	125,006.7	602.5	99.5
210301	Гэрэл, цахилгаан	19,150.0	17,459.1	1,690.9	91.2
210302	Түлш, халаалт	103,016.2	103,481.4	(465.2)	100.5
210303	Цэвэр, бохир ус	3,443.0	4,066.1	(623.1)	118.1
2104	Хангамж, бараа материалын зардал	36,406.1	35,669.2	736.9	98.0
210401	Бичиг хэрэг	3,600.0	3,589.0	11.0	99.7
210402	Тээвэр, шатахуун	25,404.8	25,402.2	2.6	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,678.0	2,678.0	-	100.0
210404	Ном, хэвлэл	723.3	-	723.3	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000.0	4,000.0	-	100.0
2105	Нормативт зардал	2,000.0	2,000.0	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000.0	2,000.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65,877.9	65,843.4	34.5	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000.0	7,970.0	30.0	99.6
210604	Урсгал засвар	57,877.9	57,873.4	4.5	100.0
2107	Томилолт, зочны зардал	3,492.0	2,411.6	1,080.4	69.1
210702	Дотоод албан томилолт	3,492.0	2,411.6	1,080.4	69.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,684.8	24,455.4	11,229.4	68.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,034.8	23,229.6	10,805.2	68.3
210803	Даатгалын үйлчилгээ	120.0	54.5	65.6	45.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250.0	105.3	144.7	42.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132.0	90.7	41.3	68.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000.0	837.0	163.0	83.7
210807	Газрын төлбөр	148.0	138.4	9.6	93.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,760.0	7,952.0	808.0	90.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000.0	7,237.0	763.0	90.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	760.0	715.0	45.0	94.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	284,268.5	250,304.3	33,964.2	88.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	261,020.5	227,156.3	33,864.2	87.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	261,020.5	227,156.3	33,864.2	87.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,248.0	23,147.9	100.1	99.6
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,748.0	21,747.9	0.1	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500.0	1,400.0	100.0	93.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	20,000.0	-	20,000.0	-
230001	Эргэж төлөгдөх зээл	20,000.0	-	20,000.0	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	976,920.2	778,367.4	198,552.8	79.7

31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	123,842.6	123,842.6	-	100.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	123,842.6	123,842.6	-	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	650,437.0	645,147.4	5,289.6	99.2
320001	Орон нутгийн төсвөөс	650,437.0	645,147.4	5,289.6	99.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	202,640.6	9,377.4	193,263.2	4.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000.0	8,051.9	11,948.1	40.3
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500.0	1,325.5	(825.5)	265.1
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	182,140.6	-	182,140.6	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	257,403.9	(257,403.9)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	160,069.5	(160,069.5)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/ ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,989.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,989.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,079.60
2104	Хангамж, бараа материалын зардал	1,443.60
210401	Бичиг хэрэг	280.00
210402	Тээвэр, шатахуун	1,133.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,736.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,736.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,910.20
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,200.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,200.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,710.20
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,710.20
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,789.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,789.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,509.80
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	280.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-1,200.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,200.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Цагааннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэх” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна

Цагааннуур сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 82.6 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх хяналтыг тавьж ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд орон нутгийн ерөнхий орлого болон 5 төсөвт байгууллага, 2 орон нутгийн сан, 1 орон нутгийн өмчит ХХК нийт 9 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Үүнээс Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулж, 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургууль мөн Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу эрүүл мэндийн төв болон Соёлын төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгжийг Засаг даргын захирамжаар 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын нэгж нь 2022 онд 9 ажил хийхээр төлөвлөж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын орон нутгийн орлого бүрдүүлэлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаа, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэл, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт зэрэг үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагааннуур сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,172.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт
төгрөгөөр/

/сая

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	399.1	363.1	(36.0)
Авлага	115.0	83.2	(31.8)
Бараа материал	439.7	48.5	(391.2)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1.7	-	(1.7)
Үндсэн хөрөнгө	4,243.5	531.7	(3,711.8)
Нийт хөрөнгө	5,199.0	1,026.5	(4,172.4)
Өр төлбөр	1.3	-	(1.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,197.7	1,026.5	(4,171.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,199.0	1,026.5	(4,172.4)

Тайланд онд мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр, үндсэн хөрөнгө, бараа материал дансанд дараах хөдөлгөөн хийгдсэн байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 36.0 сая төгрөгөөр буурсан нь орон нутгийн хөгжлийн сангийн өмнөх оны үлдэгдэл 31.9 сая төгрөгийг зарцуулсан, ЭМТ-ийн дансны үлдэгдэл 13.5 сая төгрөг улсын төсөвт шилжсэнтэй холбоотой байна.
2. Авлага дансны үлдэгдэл 31.8 сая төгрөгөөр буурахад сумын эрүүл мэндийн төвийн 23.7 сая төгрөгийн авлага улсын төсөвт шилжсэн, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 10.2 сая төгрөгөөр буурсан зэрэг нь нөлөөлсөн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 83.2 сая төгрөг байгаа ба үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 11 иргэнтэй холбоотой 65.2 сая төгрөг байна.

3. Бараа материалын дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжсэнээр нийт 398.6 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн нь нөлөөлсөн байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургууль 180.7 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 72.9 сая төгрөг, Соёлын төв 25.2 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 114.6 сая төгрөгийн бараа материалыг тус тус шилжүүлсэн байна.
4. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурахад Ерөнхий боловсролын сургуулийн 2,886.6 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэг 367.6 сая төгрөг, Соёлын төв 62.2 сая төгрөг, Эрүүл мэндийн төв 478.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт тус тус шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.
5. Өр төлбөрийн данснаас Ерөнхий боловсролын сургуулийн 1.1 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэгийн 0.2 сая төгрөгийн өглөгийг хасаж тайлагнасан байна.

Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 902.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 2,501.4 сая төгрөгөөр бууу 26.5 хувиар буурсан байна.

Хүснэгт №2 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	81.8	242.7	160.9	296.7
Татварын бус орлого	778.0	50.6	-727.4	6.5
Тусламж санхүүжилтийн орлого	2,543.6	608.7	-1934.9	23.9
Нийт дүн	3,403.4	902.0	-2501.4	26.5

Эх сурвалж: Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн тайлан

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан Ерхөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв гэсэн байгууллагууд улсын төсөвт шилжсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 868.1 сая төгрөгийн 16 орлогын давхардсан гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 773.6 сая төгрөгийн 14 орлогын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 5,063.3 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт №3: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая төгрөг/	
				зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардлын дүн		2,642.4	847.8	(1,794.6)	32.1
Бараа, ажил үйлчилгээний зардал		2,528.5	714.5	(1,814.0)	28.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,553.2	309.9	(1,243.3)	20.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		204.2	38.6	(165.6)	18.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		117.6	129.5	11.9	110.1
Хангамж, бараа материалын зардал		121.0	71.7	(49.3)	59.3
Нормативт зардал		222.2	0.1	(222.1)	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал		23.2	58.3	35.1	251.3
Томилолт, зочны зардал		5.0	2.4	(2.6)	47.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		18.7	24.1	5.4	128.9
Бараа үйлчилгээний бусад зардал		263.3	79.8	(183.5)	30.3
Урсгал шилжүүлэг		114.0	133.3	19.4	117.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	110.2	110.2	
Бусад урсгал шилжүүлэг		93.0	23.1	(69.8)	24.9
Үйл ажиллагааны бус зардлын дун		13.8	4,188.5	4,174.6	30,282.7
НИЙТ		2,656.2	5,036.3	2,380.0	30,314.8

Эх сурвалж: Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн тайлан

Нийт зардлын дүн өмнөх оноос 2,380.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан 4 байгууллага улсын төсөвт шилжиж хаалтын тайлан хийсэнтэй холбоотойгоор үйл ажиллагааны бус зардлын дүн 4,147.6 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 868.1 сая төгрөгийн зарлагын давхардсан 16 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 773.6 сая төгрөгийн зарлагын давхардсан 14 гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны орлогын төсвийн төслийг 165.6 сая төгрөгөөр нэгтгэж аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж ажилласан байна.

Цагааннуур сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 10 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 1,102.0 сая төгрөгийн төсөв баталснаас 744.9 сая төгрөгийг урсгал зардалд, 317.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, Эргэж төлөгдөх зээлийн зардалд 40.0 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 612.1 сая төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 187.9 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 175.3 сая төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, давсан орлого дансны үлдэгдлээс 126.7 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд Цагааннуур сумын ИТХ-ын 2021 оны 7 дугаар сарын 13-ны өдрийн 13 дугаар тогтоолоор төсөвт 125.1 сая төгрөгийн хасах тодотгол хийж төсвийг 976.9 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 9.8 сая төгрөгийг, орон нутгийн төсвөөс 645.1 сая төгрөгийг, орон нутгийн хөгжлийн сангаас 123.8 сая төгрөгийг нийт 778.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Цагааннуур сумын ИТХ-ын 2022 оны орон нутгийн төсвийн тодотгол батлах тухай 2022 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 13 дугаар тогтоолд зааснаар Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 178.3 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 244.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 137.3 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №4. Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	107.0	127.7	20.7	119.3
Үйл ажиллагааны орлого	3.5	1.0	(2.5)	29.5
Хөрөнгийн орлого	27.5	22.0	(5.5)	80.0
Хөрөнгө борлуулсны орлого	5.2	6.1	0.9	116.9
Шууд бус орлого	0.5	0.5	0.0	100.5
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(22.9)	(8.0)	14.9	35.1
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1.4	1.7	0.3	124.5
Бууны албан татвар	0.7	0.7	(0.0)	93.1
Малд ногдуулах албан татвар	10.5	10.1	(0.4)	96.3
Улсын тэмдэгтийн хураамж	1.5	12.5	11.0	834.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2.5	2.2	(0.3)	89.3
Газрын төлбөр	3.9	2.8	(1.1)	70.9
Дуудлага худалдаа	2.0	7.7	5.7	384.9
Ойн нөөц ашигласны төлбөр	29.6	31.1	1.4	104.9
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.3	22.6	22.3	7,374.3
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.1	0.1	-	100.0
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	2.0	2.0	-	100.0
Торгуулийн орлого	3.0	2.0	(1.0)	67.1
НИЙТ ОРЛОГО	178.3	244.8	66.5	137.3

Эх сурвалж: Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Цагааннуур сумын орон нутгийн орлого 66.5 сая төгрөгөөр давж биелэхэд цалин хөлс, хөдөлмөр эрхлэлтийн орлого 20.7 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 11.0 сая төгрөгөөр, дуудлага худалдааны орлого 5.7 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр 22.3 сая төгрөгөөр давж биелсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Үйл ажиллагааны орлого 2.5 сая төгрөгөөр, хөрөнгийн орлого 5.5 сая төгрөгөөр, малд ногдуулах албан татвар 0.4 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.3 сая төгрөгөөр, газрын төлбөр 1.1 сая төгрөгөөр, торгуулийн орлого 1.0 сая төгрөгөөр нийт 10.8 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 10.2 сая төгрөгөөр төлөвлөж 9.8 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 0.4 сая төгрөг буюу 4 хувиар тасалсан байна.

Хүснэгт №5: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ААНОАТ	0.8	0.7	-0.1
2	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	8.0	8.2	0.2
3	Зам ашигласны төлбөр	1.4	0.9	-0.5
	Нийт дүн	10.2	9.8	-0.4

Эх сурвалж: Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр авч үзвэл ААНОАТ 0.1 сая төгрөгөөр, зам ашигласны төлбөр 0.5 сая төгрөгөөр тус тус тасалсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 12.8 сая төгрөгөөр төлөвлөж 5.3 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 7.5 сая төгрөгөөр буюу 41.4 хувиар тасарсан байна.

Хүснэгт №6: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	1.2	1.1	-0.1
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	2.4	0.4	-2
3	Агаарын бохирдлын төлбөр /авто/	0.8	0.5	-0.3
Нийт дүн		4.4	2.0	-2.4

Эх сурвалж: Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл ААНОАТ 0.1 сая төгрөгөөр, дотоодын бараа үйлчилгээний НӨАТ 2.0 сая төгрөгөөр, агаарын бохирдлын төлбөр 0.3 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 616.4 сая төгрөгөөр төлөвлөж, 605.3 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 98.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 20.5 сая төгрөгийг орлогыг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 9.4 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлтийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 976.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 695.9 сая төгрөгийг урсгал зардалд, 261.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 20.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хаасан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 862.2 сая төгрөг буюу 88.3 хувьтай байна.

Хүснэгт №6 Төсвийн гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт	Хувь
II	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	976.9	862.2	114.7	88.3
21	Урсгал зардал	956.9	862.2	94.7	90.1
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	672.7	611.9	60.8	91.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349.7	309.9	39.8	88.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45.1	38.6	6.5	90.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125.6	125.0	0.6	100.5
2104	Хангамж, бараа материалын зардал	36.4	35.7	0.7	100.0
2105	Нормативт зардал	2.0	2.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65.9	65.8	0.0	68.3
2107	Томилолт, зочны зардал	3.5	2.4	1.1	93.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35.7	24.5	11.2	88.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8.8	8.0	0.8	100.0
213	Урсгал шилжүүлэг	284.3	250.3	34.0	133.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	261.0	227.2	33.9	590.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	23.2	23.1	0.1	100.0
23	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	20.0	-	20.0	

Гүйцэтгэлээр урсгал зардалд 635.0 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 227.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсвөөс 114.7 сая төгрөгийг зарцуулаагүй нь хоршоо хөгжүүлэх сангаас олгохоор төлөвлөсөн 20.0 сая төгрөгийн зээлийг олгоогүй, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан 6 төсөл арга хэмжээ дутуу хэрэгжсэнээс тайлант онд 33.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй, мөн сумын Засаг даргын Тамгын газар нь батлагдсан цалингийн сангаас 36.4 сая төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ТТЗ-ийн харьяа байгууллагууд нь хандив тусламжаар дээд шатны төсөв захирагчаас 12.5 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 0.3 сая төгрөг нийт 12.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардалд 5.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагааннуур сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 29 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 52.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 42.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан байгууллагууд улсын төсөвт шилжсэнтэй холбоотойгоор материаллаг байдлын түвшнийг тайлант оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 847.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 16.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цагааннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 7 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	12.3	3	12.3	100.0
Нийт дүн	3	12.3	3	12.3	100.0

/сая төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн ерөнхий орлого болон төсвийн шууд захирагчийн 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Үүнд:

№	Байгууллагын нэр	Аудитын дүгнэлт
1	Засаг даргын Тамгын газар	Өөрчлөлтгүй дүгнэлт
2	Ерөнхий боловсролын сургууль	Өөрчлөлтгүй дүгнэлт
3	Хүүхдийн цэцэрлэг	Өөрчлөлтгүй дүгнэлт
4	Эрүүл мэндийн төв	Өөрчлөлтгүй дүгнэлт
5	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Түүвэрт хамрагдсан
6	Соёлын төв	Түүвэрт хамрагдсан
7	Сум хөгжүүлэх сан	Түүвэрт хамрагдсан
8	Орон нутгийн хөгжлийн сан	Түүвэрт хамрагдсан

Тайлант онд Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, эрүүл мэндийн төв болон Соёлын төв гэсэн 4 байгууллага улсын төсөвт шилжсэн тул хаалтын тайлан гаргаж нэгтгэсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 291.2 сая төгрөгийн алдааг илрүүлж аудитын хугацаанд бүрэн залруулсан. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн тайланг 254.3 сая төгрөгөөр үр дүнгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланд зөрүүтэй нэгтгэсэн.
- Улсын төсөвт шилжсэн байгууллагуудын хаалтын тайланд авлага, өглөг, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 36.9 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн.

Аудитаар төсөвт төвлөрүүлэх орлогын бүрдэлт болон хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлттэй холбоотой 79.0 сая төгрөгийн зөрчил илэрч 2 зөвлөмжийг хүргүүлж байна.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 63.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч нэр төрлөөр нь авч үзвэл 13.8 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

2. Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээл 11 иргэнтэй холбоотой 65.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цагааннуур сумын ТТЗ	2	291.2			2	291.2	3	291.2				
Дүн	2	291.2			2	291.2	3	291.2	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цагааннуур ТТЗ	2	79.0					2	79.0				
Дүн	2	79.0					2	79.0	0	0	0	0
Харьяа байгууллагуудын зөрчил												
Цагааннуур сумын ЗДТГ	2	0.7					2	0.7				
Дүн	2	0.7					2	0.7				
Нийт дүн	4	79.7					4	79.7				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО: